

Захидлын утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хүмүүсийн энгийн харилцааны зорилгоор өөр хоорондоо илгээх бичгийг **захидал** гэнэ.

Бичигчийн санаа гэдэг нь тухайн үйл явдалд хэрхэн хандаж байгааг хэлнэ. Юуг онцолж байгаа нь чухал юм.

Дасгал 6. Захидлын утга, бүтцийг мэдэж аваарай.

Алхам 1. Захидлын утгыг тайлбарлаарай. Цэгийн оронд нөхөж бичнэ үү.

Сайн байна уу? Аав аа!

Таны шинэ ном гарч буйд бид бүхэн баяртай байна. Та ч биднээс илүү баярлаж байгаа байх.

Таны бие ямархуу байна? Аав минь, одоо л биеэ бодохгүй бол болохгүй шүү! Та ажил төрөл гээд биеэ зөнд нь орхиод байдаг талтайгаа ойлгоорой. Аль болохоор тайван байхыг бод. Эм тариа чинь олдож байна уу? Олдохгүй зүйлээ бидэнд утсаар хэлчихгүй юу?

Би шалгалтаа амжилттай өгч, оройн сургуульд орсон. Өглөө ажилдаа яваад, орой 17-21 цаг хүртэл хичээлээ хийж байна. Хичээл нь ч яах вэ, одоохондоо гайгүй л юм байна.

Ээж амарч эхэлсэн. Ганхөлөг амраад, маргаашаас хичээлдээ орно. Бусад нь ажил сургуульдаа явж байгаа. Батаа, Нараа хоёр хагас бүтэн сайнаар манайд ирдэг. Тэгэхдээ таныг дандаа асуудаг. Өвөө хэзээ ирэх вэ? гээд л шалгааж гарна даа. Одоо ч таны ирэх хугацаа дөхөж байгаа биз дээ?

Бид таны сая гаргасан шинэ номоос 10 ширхгийг авсан. Тавыг нь танд явууллаа. Ямар ч номыг хэвлэлээс гарсны дараа уншихад улам ч гоё болчихсон юм шиг санагддаг юм. Охин чинь хэзээ номоо унших юм бол доо.

За баяртай. Биеэ л сайн бодож, хямгадаж яваарай, аав аа!

Гүнээ хүндэтгэсэн охин Дэлгэрмаа
1988 оны 11-р сарын 9-нд бичив.

Бичигчийн сэтгэл хөдлөлийг харуулсан хэсэг


Захиагаа төгсгөснөө илэрхийлсэн хэсэг

Алхам 2. Эхийн бүтцийн хэсэгт тус бүрд захидлын аль цогцолбор хамаарах вэ? Холбож зураарай.

Эхлэл хэсэг

Гол хэсэг

Төгсгөл хэсэг



Амар мэндийг асуусан хэсэг

Бичигчийн сэтгэл хөдлөлийг харуулсан хэсэг

Сонин сайхан, болж байгаа хэрэг явдлыг харуулсан хэсэг

Захиагаа төгсгөснөө илэрхийлсэн хэсэг